



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/453

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Архив, Улсын бүртгэлийн газрын барилгын зураг төсөв гаргахаар манай аймагт ажилласан ажлын хэсгийн байрны зардалд 1 473 300 төгрөг, Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтнууд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид манай аймагтай танилцаж, хамтран ажиллах санал солилцсон уулзалтын зардалд 643 000 төгрөг, манай аймагт ирсэн зочид төлөөлөгчдийн гарын бэлэг бэлтгэх зардалд 605 000 төгрөг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 2 721 300 төгрөг /Хоёр сая долоон зуун хорин нэгэн мянга гурван зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ